

Үнэт цаас гаргагчийн түүх, үйл ажиллагааны төрөл, хэтийн төлөв, үйлдвэрлэл үйлчилгээний үндсэн чиглэл, тухайн зах зээлд үнэт цаас гаргагчийн эзлэх байр суурийн талаархи мэдээлэл, судалгаа:

Оллоо ХХК нь 2004 оноос эхлэн вэб программчлал, онлайн зар сурталчилгаа, үйлчилгээг үзүүлж www.olloo.mn сайтыг бүтээн интернет хэрэглэгчдийн хамгийн өргөн үйлчлүүлдэг, өөрийн байр сууриа олсон үндэсний тэргүүлэх компани болж чаджээ.

Эрхэм зорилго

Олсон амжилтаа улам бэхжүүлж, шинээр гарч буй техник, технологийн дэвшлийг өөрийн үйл ажиллагаандаа нэвтрүүлж, хэрэглэгчиддээ чанартай, түргэн шуурхай үйлчилгээг үзүүлэх.

Оллоо ХХК нь нийгэм, цаг үеийн шуурхай шинэлэг мэдээ мэдээлэл, соёл урлаг, уран зохиол, спорт чөлөөт цаг, цаг агаар, ханшийн мэдээлэл, MP3 архив, зурхай, онигоо, гэр бүл эрүүл мэнд, гоо сайхан, хууль эрх зүй, сэтгэл зүй, зургийн цомог, сонжоо зар сурталчилгаа зэрэг арав гаруй салбарт зуу орчим мэдээллийн төрлүүдийг багтаасан монгол хүмүүсийн оюуны хэрэгцээг хангахуйц www.olloo.mn сайтыг ажиллуулж эхлээд байна.

Одоогоор манай сайтад давхардаагвй тоогоор едер бвр 180 гаруй мянган хэрэглэгч тогтмол орж хэрэгтэй мэдээллээ авдаг бегеед нийт уншигчдын 30 орчим хувийг гадаадад байгаа монголчууд эзэлдэг ба үлдэх хувийг монгол улс дотроос хандсан байдаг. Энэ хандалтын тоо нь өдрөөс өдөрт нэмэгдэж байгаа нь бидэнд улам бүр урам зориг оруулж байдаг.

Манай компаний зорилгуудын нэг нь нийт интернэт хэрэглэгчид, түүний дотор гадаад оронд ажиллаж, сурч амьдарч байгаа иргэдэдээ эх орныхоо талаар өргөн мэдээллийг цаг тухайд нь бодитойгоор авах боломж олгох явдал юм. Мөн орон нутгийн ард иргэддээ электрон хэвлэлээр едер бвр шинэ мэдээ мэдээллийг хвргэж, хvmvvсийн интернэтийн хэрэглээг ергежvвлэхийг зорьж байна. Цаашилбал дээр дурьдсанаар интернэтийг ашиглан өөрийн цаг хугацаагаа хэмнэж, хийж байгаа болон хийх ажлаа хялбаршуулах хөдөлмөрийн бүтээмжээ дээшлүүлэх зэрэг интернэтийн асар их боломжийг ашиглан маш олон зүйлийг бүтээхэд чиглэж байгаа юм.

Бид зөвхөн цаг veийн мэдээ мэдээллийг олон нийтэд хвргээд зогсохгvй нийгмийн салбар тус бvртэй холбогдолтой мэдээллийн санг бvрдvвлэх, уншигчдад мэргэжлийн байгууллага хvmvvсийн заавар зөвлөгөөг егч байх, тэдэнд vнэн зөв бодитой мэдээллийг цаг тухайд нь хвргэж байхыг чармайдаг.

Манай компани нь зөвхөн хэвлэл мэдээллийн сvлжээ байгаад зогсохгvй техник технологийн ендер хөгжлийг даган орон зай, цаг хугацаанд vл хязгаарлагдах худалдаа арилжааны шинэ хэлбэр болох онлайн худалдааг монголд жинхэнэ утгаар нь хөгжvвлэх vвднээс «Интернэтийн их дэлгvвр»-ийг нээн ажиллуулж эхлээд байна. Энэ нь хэрэглэгч сонирхсон бараа товараа эндээс илvv хямдаар худалдан авахаас гадна www.olloo.mn сайтаар дамжуулан бараа бvтээгдэхvvnээ зарж борлуулах, худалдан авагчдынхаа хvрээг тэлэх ерген боломж нээгдэж байгаа юм.

Бидний эрхэм зорилгын нэг хэсэг болох гадаадад болон хөдөө орон нутагт ажиллаж амьдарч байгаа иргэддээ монгол улсад өрнөж буй халуун мэдээ мэдээллийг цаг алдалгүй бодитоор хүргэж иргэдийн интернетийн хэрэглээг өргөжүүлэхийг зорин ажиллаж байна.

Өнөөдрийг хүртэл бид

Оллоо ХХК-ийн хамт олон өөрийн салбарын онцлог, эрэлт хэрэгцээг судалж, тэдгээртэй холбоотой мэдээллийн санг бүрдүүлж ирснээр хэрэглэгчдийн зан төлөв, тэдний хүсч буй мэдээллийг өөрийн хэвлэн нийтлэх бодлоготой уялдуулж ажилласнаар эдүгээ Монголын хамгийн олон уншигчтай вэбсайт болжээ.

Компанийн техникийн үзүүлэлт:

Оллоо ХХК нь 4 rack, 1 Пи Си сервер, 1 хостингтэй нийт 6 сервертэй бөгөөд байршуулалтын хувьд мажикнет дээр 3, Жинет дээр нэг 1- дотоод сүлжээгээ давхар хангадаг, рэйлком дээр 1 тус тус байршиж байна. Linux System бууж програмчлалын php, MySQL /бүх subdomain нийлээд 500-600 mb, php зураг нийлээд 10-20 mb/ , html, javascript дээр бичиж байна.